



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/113

Улаан-Уул

Байгаль хамгаалах арга
хэмжээний зардлаас хөрөнгө
зарцуулах тухай олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Өлзийт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 12 дугаар сарын 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө зарцуулах зөвлөлийн 2022 оны 09 сарын 08-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн бүх нийтийг хамарсан хог хаягдлын цэвэрлэгээ хийсэн зардал 552,600 (Таван зуун тавин хоёр мянга зургаан зуун) төгрөг, байгаль орчныг хамгаалах, эргүүл, хяналтын 8 сарын шатахууны зардал 527,200 (Таван зуун хорин долоон мянга хоёр зуун) төгрөг, ланд 80 авто машины татвар, даатгалын зардал 251,589 (Хоёр зуун тавин нэгэн мянга таван зуун наян ес) төгрөг, байгаль хамгаалагчийн унаа мотоцикль, ажлын хувцас, бие хамгаалах тусгай хэрэгслийн зардал 4,500,000 (Дөрвөн сая таван зуун мянган) төгрөг, "Аюулыг авдарлая-1" уралдааныг сумд зохион байгуулах удирдамжийн шагнал 110,000 (Нэг зуун арван мянган) төгрөгийг тус зарцуулсугай.

2. Уг хөрөнгийг байгаль хамгаалах арга хэмжээний зардлаас зарцуулахыг Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдорж)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201229